



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/66

Мяндалговь

**Насанд хүрэгчдийн шатрын аварга
шалгаруулах тэмцээн зохион байгуулах тухай**

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5, 20.5.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өсвөр үе, залуучуудын дунд шатрын спортыг түгээн дэлгэрүүлэх, авьяас билгийг нээн хөгжүүлэх зорилгоор "Аймгийн насанд хүрэгчдийн шатрын аварга" шалгаруулах тэмцээнийг 2020 оны 10 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар, төсвийн 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. "Аймгийн насанд хүрэгчдийн шатрын аварга" шалгаруулах тэмцээн зохион байгуулахад шаардагдах 1200000 (Нэг сая хоёр зуун мянга) төгрөгийн зардлыг нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Залуучуудын хөгжлийн төвийн ажлын албаны нарийн бичиг, ажлын хэсгийн ахлагч (Х.Төмөрбат), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Төмөрбат)-д даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

491190135

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
10 дугаар тушаалын 2.1 дүгээр хавсралт



ДУНДГОВЬ АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН STANDART БОЛОН BLITZ ТОГЛОЛТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ШАТРЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Тэмцээний зорилго: Хүүхэд багачууд болон насанд хүрэгчдийн дунд шатрын спортыг сурталчилан дэлгэрүүлэх, тэдний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, орон нутагт оюуны спортоор өргөнөөр хичээллэхийг дэмжих, тэдний ур чадвар, авьяас билгийг нээн хөгжүүлэхэд оршино.

Тэмцээний хугацаа, байршил: STANDART төрөл 2020 оны 10 сарын 17-18-ны өдрүүдэд аймгийн /Төв цэнгэлдэх хүрээлэнд/

BLITZ төрөл 2020 оны 10 сарын 18-ны 16 цагт эхлэнэ.

Тэмцээний бүртгэл: 2020 оны 10 сарын 15-ны 09:00 цагт эхэлж, 10 сарын 16-ны 18:00 цагт хаана. Оролцох багууд мэдүүлгээ **М.Билгүүн** гэсэн facebook хаягаар 10 сарын 16-ны өдөр ирүүлсэн байна.

Тэмцээний ангилал: Насанд хүрэгчид эрэгтэй, эмэгтэй гэсэн 2 ангилалд тоглоно.

Тэмцээн зохион байгуулах журам: STANDART төрөл Швейцар системээр оролцогчдын тооноос хамаарч 7-9 өрөг тоглуулна. Оролцогчдын тоо 9 ба түүнээс бага бол тойргийн системээр тоглоно. Цагийн хяналт талдаа 60 минут байна. Тэмцээнийг FIDE-н дүрмийн дагуу явуулна. BLITZ төрөл Швейцар системээр оролцогчдын тооноос хамаарч 5-7 өрөг тоглоно. Цагийн хяналт талдаа 5 минут.

Тэмцээний зохион байгуулагчид:

- Дундговь аймгийн шатрын холбоо ТББ
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- Биеийн тамир спортын газар

Тэмцээний шагнал урамшуулал: Эрэгтэй, эмэгтэй ангилал тус бүр

1-р байр өргөмжлөл, алтан медаль, мөнгөн шагнал

2-р байр өргөмжлөл, мөнгөн медаль, мөнгөн шагнал

3-р байр өргөмжлөл, хүрэл медаль, мөнгөн шагнал

Тусгай байр 13 нас хүртлэх хүүхэд өргөмжлөл, мөнгөн шагнал

Тусгай байр 16 нас хүртлэх хүүхэд өргөмжлөл, мөнгөн шагнал

Багийн шагнал: Тэргүүн байр өргөмжлөл, мөнгөн шагнал

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2020 оны 42 дугаар сарын 24-ны өдрийн
1466 дугаар тушаалын 0.2 дугаар хавсралт



**ДУНДГОВЬ АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ШАТРЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Төмөрбат

Залуучуудын хөгжлийн төвийн
ажлын албаны нарийн бичиг

Гишүүд

Б.Пүрэвжаргал

Залуучуудын хөгжлийн төвийн сургалт
хариуцсан ажилтан

Д.Саранзаяа

Залуучуудын хөгжлийн төвийн оролцоо,
хамтын ажиллагаа хариуцсан ажилтан

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2020 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн
А/66 дугаар тушаалын 02 дугаар хавсралт



**ДУНДГОВЬ АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ШАТРЫН ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ**

№	Материалын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо	Хэмжих нэгж	Нийт үнэ
1	Тэргүүн байр	200.000	2	Хүн	400.000
2	Дэд байр	150.000	2	Хүн	300.000
3	Гутгаар байр	100.000	2	Хүн	200.000
4	Тусгай байр 13 хүртлэх нас	50.000	2	Хүн	100.000
5	Тусгай байр 16 хүртлэх нас	50.000	2	Хүн	100.000
6	Багийн шагнал тэргүүн байр	100.000	1		100.000
Нийт					1.200.000